



MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

20²³ оны 02 сарын 03.-ны өдөр

Дугаар .06

Улаанбаатар хот

**ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах,
нэр дэвшүүлэх журам батлах тухай**

Говь ХК-ийн “Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг хангах хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах, засаглалын тогтолцоог бэхжүүлэх зорилгын хүрээнд ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх журмыг батлах тухай асуудлыг хэлэлцэн, Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалтыг үндэслэн Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

Нэг. Говь ХК-ийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх журам”-ыг Хавсралт-1 ёсоор баталсугай.

Хоёр. Энэхүү журмыг үйл ажиллагаандaa хэрэгжүүлэн ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нийт гишүүд, Гүйцэтгэх захирал /Ц.Баатарсайхан/, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /М.Сэлэнгэ/ нарт үүрэг болгосугай.







Д.ГЭРЭЛМАА

GOBI MONGOLIAN CASHMERE	ТУЗ-ИЙН ГИШҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ, НЭР ДЭВШҮҮЛЭХ ЖУРАМ	УДИРДАХ ЗӨВЛӨЛ Дугаар: TTN2998 №.2076357 Ж-ТУЗ-134-01
-----------------------------------	--	---


БАРИМТ БИЧГИЙН НЭР:

**ГОВЬ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНИЙГ
СОНГОН ШАЛГАРУУЛАХ, НЭР ДЭВШҮҮЛЭХ ЖУРАМ**

БАРИМТ БИЧГИЙН ХАРИУЦАГЧ	ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА		
БАРИМТ БИЧГИЙН ХАМРАХ ХҮРЭЭ	ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ, ТУЗ-ИЙН ГИШҮҮД, НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО, ТУЗ-ИЙН АЖЛЫН АЛБА, ТУЗ-ИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧ, ОЛОН НИЙТ		
БАТЛАГДСАН ОГНОО	2023.02.03		
БАРИМТ БИЧГИЙН НУУЦЛАЛЫН ЗЭРЭГЛЭЛ	НЭЭЛТТЭЙ	БАРИМТ БИЧГИЙН ТҮВШИН	T2

	АЛБАН ТУШААЛ	НЭР	ГАРЫН ҮСЭГ
БАТАЛСАН:	ТУЗ-ИЙН ДАРГА	Д.ГЭРЭЛМАА	
ХЯНАСАН:	ТУЗ-ИЙН ГИШҮҮН	Ц.БААТАРСАЙХАН	
	ТУЗ-ИЙН ГИШҮҮН	М.БАЯР	
	ТУЗ-ИЙН ГИШҮҮН	Ж.ОЮУНЧИМЭГ	
	ТУЗ-ИЙН ГИШҮҮН	А.ЖАРГАЛМАА	
	ТУЗ-ИЙН ГИШҮҮН	Д.ХУЛАН	

GOBI MONGOLIAN CASHMERE	ТУЗ-ИЙН ГИШҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ, НЭР ДЭВШҮҮЛЭХ ЖУРАМ	Дугаар: Ж-ТУЗ-134-01
-----------------------------------	--	-------------------------

	ТУЗ-ИЙН ГИШҮҮН	Д.ХҮРЭЛБААТАР	
	ТХХ-ИЙН ДАРГА	Э.ИВГЭЭЛ	
БОЛОВСРУУЛСАН:	ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА	М.СЭЛЭНГЭ	


Улаанбаатар хот

2023 он

Баримт бичгийн өөрчлөлтийн бүртгэл

Хувилбарын дугаар	Хүчин төгөлдөр болсон огноо	Өөрчлөлт оруулж, боловсруулсан албан тушаалтан	Өөрчлөлтийн утга (баримт бичигт ямар өөрчлөлт орсныг товч тайлбарлана)
01	2023.02.03	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ	Баримт бичгийн анхны хувилбар

Баримт бичгийн төлөв

Эх хувь	Албан хэрэгцээний хувь	Хүчингүй хувь
		

ИШ ТАТСАН БАРИМТ БИЧГҮҮД

№	Баримт бичгийн нэр	Бүртгэлийн дугаар
1	"Компанийн тухай хууль"	УИХ-ын 2011.10.06-ны хурлаар батлагдсан, сүүлд 2022.06.17-нд нэмэлт өөрчлөлт орсон.
2	"Компанийн засаглалын кодекс"	СЗХ-ны 2022.03.23-ны №145 тогтоол
3	"Говь ХК-ийн дүрэм"	Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2020.04.24-ний №02 тогтоол
4	Говь ХК-ийн "ТУЗ-ийн үйл ажиллагааны журам"	Ж-ТУЗ-26-02
5	Говь ХК-ийн "Нэр дэвшиүүлэх хорооны дүрэм"	Д-ТУЗ-03-01
6	Говь ХК-ийн "Олон нийтэд хүргэх мэдээллийн журам"	Ж-ТУЗ-104-02

	ТУЗ-ИЙН ГИШҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ, НЭР ДЭВШҮҮЛЭХ ЖУРАМ	Дугаар: Ж-ТУЗ-134-01
---	--	---------------------------------------

АГУУЛГА

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	5
1.1 Зорилго.....	5
1.2 Хамрах хүрээ	5
1.3 Нэр томьёоны тайлбар	5
1.4 Эрх, үүргийн матриц.....	7
2. ТУЗ-ИЙН ГИШҮҮН СОНГОН ШАЛГАРУУЛАХАД ГАЗАР НЭГЖҮҮДИЙН ЭРХ, ҮҮРЭГ	
2.1 ТУЗ-ийн ажлын албаны эрх, үүрэг	7
2.2 ТУЗ-ийн эрх, үүрэг	8
2.3 Нэр дэвшигчийн хорооны эрх, үүрэг	8
2.4 Хувьцаа эзэмшигчдийн хурлын эрх, үүрэг	8
3. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА	8
3.1 Баримтлах зарчим	8
3.2 Сонгон шалгаруулалт зохион байгуулах арга хэлбэр.....	9
3.3 ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчид тавигдах шалгуур	10
4. ТУЗ-ИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙГ БҮРТГЭХ, СОНГОН ШАЛГАРУУЛАХ ...	12
4.1 Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчээс нэр дэвшигчийн санал оруулах	12
4.2 Сонгон шалгаруулалт зохион байгуулах шийдвэр гаргах	13
4.3 Нэр дэвшигчдийг үнэлэх, сонгон шалгаруулах үйл ажиллагаа явуулах.....	14
5. ТУЗ-ИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШҮҮЛЭХ, ТОМИЛОХ.....	14
5.1 ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч.....	14
5.2 ТУЗ-ийн гишүүнийг томилох.....	14
6. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА	15
6.1 Хяналт тавих.....	15
6.2 Хариуцлага хүлээлгэх	15
7. ХАВСРАЛТУУД	16
Хавсралт №1 ТУЗ-ийн гишүүн сонгон шалгаруулах, нэр дэвшигчийн процессын зураглал	16
Хавсралт №2 ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийн үнэлгээний хуудас	18
Хавсралт №3 ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийн анкетын загвар.....	22

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Зорилго

1.1.1 Энэхүү журмын зорилго нь Говь ХК (цаашид “Компани” гэх)-ийн ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх, томилох үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2 Хамрах хүрээ

1.2.1 Энэхүү журам нь олон нийтэд нээлттэй байх бөгөөд компанийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч, Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн гишүүд, Нэр дэвшүүлэх хороо, ТУЗ-ийн ажлын албанад хамаарна.

1.3 Нэр томьёоны тайлбар

1.3.1 Уг журмын хүрээнд дараах нэр томьёог ашиглана.

1.3.1.1 **Нэр дэвшүүлэх хороо:** ТУЗ-ийн дэргэдэх хороо бөгөөд компанийн ТУЗ-ийн гишүүн болон Гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох, тус шалгуурыг хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийг бүртгэн сонгон шалгаруулалт хийж, ХЭХ-д шууд нэр дэвшүүлэх эрх бүхий хороо;

1.3.1.2 **ТУЗ-ийн гишүүний сонгон шалгаруулалтад оролцогч:** Компанийн зүгээс зарласан ТУЗ-ийн гишүүний сонгон шалгаруулалтад оролцож, нэр дэвших хүсэлтээ өгсөн хувь хүн;

1.3.1.3 **ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч:** Компанийн ТУЗ-ийн гишүүний сонгон шалгаруулалтад орж, Нэр дэвшүүлэх хорооны зүгээс тогтоосон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэлт дүгнэлт хийсний үндсэн дээр ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэхээр сонгогдсон хувь хүн;

1.3.1.4 **ТУЗ-ийн ердийн гишүүн:** Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшдэг, компанийн болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаал эрхэлдэг, эсхүл сүүлийн 3

	ТУЗ-ИЙН ГИШҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ, НЭР ДЭВШҮҮЛЭХ ЖУРАМ	Дугаар: Ж-ТУЗ-134-01
---	--	--------------------------------

жилийн хугацаанд ажил, албан тушаал эрхэлж байсан, мөн компанийтай бизнесийн аливаа холбоотой ТУЗ-ийн гишүүн;

- 1.3.1.5 **ТУЗ-ийн хараат бус гишүүн:** Компанийн тухай хуулийн 79.1-д заасан шалгуурыг хангасан буюу, өөрөө эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшдэггүй, компанийн болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаал эрхэлдэггүй, сүүлийн 3 жилийн хугацаанд ажил, албан тушаал эрхэлж байгаагүй, төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй, хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад шаардлагыг хангасан, компанийтай бизнесийн холбоо хамааралгүй, аливаа шийдвэрийг хараат бусаар гаргах үүрэг хүлээсэн ТУЗ-ийн гишүүн;
- 1.3.1.6 **Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч:** Компанийн саналын эрх бүхий энгийн хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмшиж байгаа этгээд, тэдгээрийн эцсийн өмчлөгч хүн;
- 1.3.1.7 **Эрх бүхий албан тушаалтан:** Компанийн ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал, дэд захирлууд, газрын захирлууд, хуулийн зөвлөх зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцог этгээд;

1.3.2 Товчлол: Баримт бичигт дор дурдсан товчилсон үгийг ашиглаж болно.

Хүснэгт 1 Товчилсон үгийн тайлбар

№	Товчилсон үгийн тайлбар	Товчилсон үг
1	Хувьцаа эзэмшигчдийн хурал	ХЭХ
2	Төлөөлөн удирдах зөвлөл	ТУЗ
3	Нэр дэвшүүлэх хороо	НДХ
4	Эрх бүхий албан тушаалтан	ЭБАТ
5	Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын алба	ТУЗАА

1.4 Эрх, үүргийн матриц

Хүснэгт 2 ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшигчийг эрх үүргийн матриц

Процесс	ХЭХ	ТУЗ	НДХ	ТУЗАА
<i>/Г-гүйцэтгэх, Х-хариуцах, З-зөвлөлдөн хамтран ажиллах, М-мэдээлэл авах/</i>				
Нэр дэвшигчид тавигдах шалгуурыг тогтоох	M	3, M	X, Г	Г
ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах эсэхийг шийдэх, сонгон шалгаруулалт зарлах шийдвэрийг гаргах	M	3, Г	X, Г	3
Сонгон шалгаруулалт зарлах, бүртгэх	M	3, M	Г	X, Г
Нэр дэвшигчдийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх, дүгнэлт өгөх	M	3, M	X, Г	3
Нэр дэвшигчдийг батлах	M	3, M	X, Г	3
ТУЗ-ийн хараат бус гишүүнийг түр томилох	M	X, Г	3	3
ТУЗ-ийн гишүүдийг томилох	X, Г	3	3	3
ТУЗ-ийн гишүүдийн сонгон шалгаруулалт, нэр дэвшигчийг үйл ажиллагаанд хяналт тавих	X	-	-	3
ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтийг олон нийтэд мэдээлэх	M	M	M	X, Г

2. ТУЗ-ИЙН ГИШҮҮН СОНГОН ШАЛГАРУУЛАХАД ГАЗАР НЭГЖҮҮДИЙН ЭРХ, ҮҮРЭГ

2.1 ТУЗ-ийн ажлын албаны эрх, үүрэг

- 2.1.1 Журмыг Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс болон компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын хүрээнд ТУЗАА-наас боловсруулан, НДХ-ны зүгээс хянаж ТУЗ-ийн хурлаар батална.
- 2.1.2 ТУЗАА нь ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн сонгон шалгаруулалтыг зарлах, сонгон шалгаруулалтад оролцогчдыг бүртгэх, материалыг нь бүрдүүлэх, НДХ-ны хурлаар хэлэлцэх бэлтгэлийг хангана.

	ТУЗ-ИЙН ГИШҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ, НЭР ДЭВШҮҮЛЭХ ЖУРАМ	Дугаар: Ж-ТУЗ-134-01
---	--	--------------------------------

2.1.3 ТУЗАА нь ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон тухай бүр компанийн “Олон нийтэд хүргэх мэдээллийн журам”-ын дагуу мэдээллийг олон нийтэд хүргэж, мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг хангана.

2.2 ТУЗ-ийн эрх, үүрэг

2.2.1 ТУЗ нь удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан, эсхүл нас барсан ТУЗ-ийн гишүүнийг орлох этгээдийг ХЭХ-аар сонгох хүртэл түр томилж болно.

2.3 Нэр дэвшүүлэх хорооны эрх, үүрэг

2.3.1 НДХ нь ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах эсэхийг шийдэн, сонгон шалгаруулалтыг дотоод эсхүл гадаад эх үүсвэрээс зарлах шийдвэрийг гаргана.

2.3.2 ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчид тавигдах шалгуур үзүүлэлтийг тогтоон, тус шалгуурын дагуу нэр дэвшигчдийг үнэлэн дүгнэлт өгч ХЭХ-д нэр дэвшүүлэх нэр дэвшигчдийг батална.

2.4 Хувьцаа эзэмшигчдийн хурлын эрх, үүрэг

2.4.1 Хувьцаа эзэмшигч нар ТУЗ-ийн гишүүдийн сонгон шалгаруулалт, нэр дэвшүүлэх үйл ажиллагаа хууль дүрэм журмын дагуу явагдсан эсэхэд хяналт тавих эрхтэй бөгөөд ХЭХ-аар ТУЗ-ийн гишүүдийг санал хураах кумулятив аргаар сонгон томилно.

3. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

3.1 Баримтлах зарчим

- 3.1.1 **Хууль, дүрэм журмыг мөрдөх:** ТУЗ-ийн гишүүний сонгон шалгаруулалтыг явуулах болон нэр дэвшүүлэхдээ Монгол улсын хууль тогтоомж болон компанийн дүрэм журмыг мөрдөн, хэрэгжилтийг хангана.
- 3.1.2 **Ил тод, нээлттэй байдлыг хангах:** ТУЗ-ийн хараат бус гишүүний сонгон шалгаруулалтыг олон нийтэд нээлттэй байдлаар зохион байгуулах бөгөөд хувьцаа эзэмшигч нараас хүсэлт гаргасан тохиолдолд сонгон шалгаруулалтын явц, үр дүнг ил тодоор мэдээлнэ.

- 3.1.3 **Мэргэшсэн, олон талт, үр дүнтэй бүтцийг бүрдүүлэх:** ТУЗ-ийн гишүүдийг олон талт үр чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал, хүйсийн тэнцвэр зэргийг зохистойгоор хангасан, бүтээлч, үр дүнтэй бүтэцтэй байхаар бүрдүүлнэ.
- 3.1.4 **Компанийн үйл ажиллагаа, стратегийн зорилттой уялдуулах:** ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнийг шинэчлэх, шинээр нэр дэвшигчдээс гишүүний хэрэгцээ, шаардлагыг тодорхойлоходоо компанийн үйл ажиллагааны онцлог, урт хугацааны стратегийн зорилго зорилттой уялдуулна.
- 3.1.5 **Тогтвортой байдлыг хангах:** ТУЗ-ийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хадгалах зорилгоор ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахдаа нэг удаад 1/3-ээс ихгүй гишүүдийг өөрчилнэ.
- 3.1.6 **Шударга, ёс зүйтэй байх:** ТУЗ-ийн гишүүний сонгон шалгаруулалтыг явуулахдаа компанийн эрх ашгийг хүндэтгэн, шударга, ёс зүйтэй хандана.

3.2 Сонгон шалгаруулалт зохион байгуулах арга хэлбэр

3.2.1 Нээлттэй сонгон шалгаруулалт зохион байгуулах

- 3.2.1.1 ТУЗ-ийн хараат бус гишүүний сонгон шалгаруулалтыг нээлттэй зарлах байдлаар буюу гадаад эх үүсвэрээс бүрдүүлж зохион байгуулах тохиолдолд ТУЗАА дараах хэлбэрүүдээс сонгож олон нийтэд сонгон шалгаруулалтын зарыг түгээнэ:
- Компанийн албан ёсны веб хуудас;
 - Компанийн албан ёсны фэйсбуук хуудас; болон
 - Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл.
- 3.2.1.2 Сонгон шалгаруулалтын зарыг олон нийтэд мэдээлснээс хойш ажлын 5-аас доошгүй хоногийн хугацаанд нэр дэвшигчдээс материал хүлээн авна.
- 3.2.1.3 Сонгон шалгаруулалтын зард дараах мэдээллийг тодорхой тусгана:
- ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчид тавигдах шалгуур үзүүлэлт;
 - Материал хүлээн авах хаяг, хугацаа, холбоо барих мэдээлэл; ба
 - ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийн анкетын загвар (энэ журмын хавсралт №3).

	ТУЗ-ИЙН ГИШҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ, НЭР ДЭВШҮҮЛЭХ ЖУРАМ	Дугаар: Ж-ТУЗ-134-01
---	--	--------------------------------

3.2.1.4 ТУЗ-ийн хараат бус гишүүний сонгон шалгаруулалтад оролцогчоос дараах баримт бичгийг хүлээн авна:

- Сонгон шалгаруулалтад оролцохыг хүссэн өргөдөл;
- ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийн анкет, цээж зураг;
- Ажил байдлын тодорхойлолт (ажил эрхэлдэг иргэн байгууллагаасаа тодорхойлолт авах, ажил эрхэлдэггүй иргэн өөрийн хийж гүйцэтгэсэн ажлын талаарх мэдээлэл);
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Боловсролын диплом, үнэмлэх, гэрчилгээний хуулбар;
- Компанийн засаглалын сургалтад хамрагдсан гэрчилгээний хуулбар;
- Оршин суугаа газрын тодорхойлолт;
- Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт; ба
- Шаардлагатай гэж үзсэн бусад нэмэлт материал.

3.2.1.5 ТУЗАА нь сонгон шалгаруулалттай холбоотой нэмэлт баримт бичиг, лавлагаа, мэдээллийг эрх бүхий байгууллагаас гаргуулан авч болно.

3.2.1.6 ТУЗАА нь нэр дэвшигчдээс ирсэн бичиг баримт, материалыг хүлээн авч, дугаарлан бүртгэж, архивлан хадгална.

3.2.2 *Өмнөх сонгон шалгаруулалтад оролцсон нэр дэвшигчдээс сонгон шалгаруулах*

3.2.2.1 Өмнө нь сонгон шалгаруулалтад материалыа ирүүлж байсан нэр дэвшигчдийн дундаас сонгон шалгаруулалтыг зохион байгуулах тохиолдолд ТУЗАА нь боломжит нэр дэвшигчдийн анкет, материалыг НДХ-ны гишүүдэд хүргүүлнэ.

3.3 ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчид тавигдах шалгуур

3.3.1 ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчид тавигдах шалгуур

3.3.1.1 Компанийн тухай хуульд заасан шалгуур үзүүлэлт:

- Иргэний эрх зүйн бүрэн чадамжтай буюу иргэн өөрийн үйлдлээр өөртөө эрх олж, үүрэг бий болгох чадвартай, 18 ба түүнээс дээш

- настай байх;
- Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, цэрэг, цагдаа, шүүх, прокурорын байгууллагад удирдах албан тушаал, төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй байх;
 - Тухайн цаг хугацаанд ял шийтгэл эдлээгүй, эрүүгийн гэмт хэрэгт сэжиглэгдээгүй байх; ба
 - Компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байх.

3.3.2 ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД ТАВИГДАХ ШАЛГУУР

3.3.2.1 Компанийн тухай хуульд заасан шалгуур үзүүлэлт:

- Иргэний эрх зүйн бүрэн чадамжтай буюу иргэн өөрийн үйлдлээр өөртөө эрх олж, үүрэг бий болгох чадвартай, 18 ба түүнээс дээш настай байх;
- Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, цэрэг, цагдаа, шүүх, прокурорын байгууллагад удирдах албан тушаал, төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй байх;
- Тухайн цаг хугацаанд ял шийтгэл эдлээгүй, эрүүгийн гэмт хэрэгт сэжиглэгдээгүй байх;
- Компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байх;
- Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшдэггүй байх;
- Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаал эрхэлдэггүй, эсхүл сүүлийн 3 жилийн хугацаанд ажил, албан тушаал эрхэлж байгаагүй байх; ба
- Компанитай бизнесийн аливаа холбоогүй байх.

3.3.2.2 Нэмэлт шалгуур үзүүлэлт:

- Компанийн ЭБАТ-тай нэгдмэл сонирхолтой биш, тэдгээрийн төрөл

	ТУЗ-ИЙН ГИШҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ, НЭР ДЭВШҮҮЛЭХ ЖУРАМ	Дугаар: Ж-ТУЗ-134-01
---	--	--------------------------------

- садан, гэр бүлийн гишүүн биш байх;
- Компанитай ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг, өрсөлдөгч байгууллагад ажил үүрэг хашдаггүй байх;
 - Ажиллаж буй мэргэжлийн чиглэлээрээ 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай байх;
 - Бизнесийн удирдлагын туршлагатай байх;
 - Санхүү, эдийн засгийн суурь мэдлэгтэй байх;
 - Ноос ноолуур, хөнгөн үйлдвэрлэлийн салбарын мэдлэгтэй байх;
 - Хангалттай цаг зарцуулж ажиллах боломжтой байх;
 - Ёс суртахууны өндөр төлөвшилтэй байх;
 - Идэвх санаачилгатай, хариуцлагатай байх;
 - Аливаа асуудалд дүн шинжилгээ хийж, асуудлыг оновчтой шийдвэрлэх чадвартай; ба
 - НДХ-ноос шинээр бүрдүүлэх ТУЗ-ийн гишүүний хэрэгцээ шаардлагатай уялдуулан тодорхойлсон бусад нэмэлт шалгуур.

4. ТУЗ-ИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙГ БҮРТГЭХ, СОНГОН ШАЛГАРУУЛАХ

4.1 Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчээс нэр дэвшигчийн санал оруулах

- 4.1.1 Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх хүний талаарх саналаа Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулахаар өмнөх санхүүгийн жил дууссанаас хойш 60 хоногийн дотор НДХ, эсхүл Гүйцэтгэх захиралд гаргаж болно.
- 4.1.2 Гүйцэтгэх захирал нь энэ журмын 4.1.1-д заасны дагуу ирүүлсэн саналыг НДХ-нд ажлын 3 өдөрт багтаан хүргүүлнэ.
- 4.1.3 Энэ журмын 4.1.1-д заасан хувьцаа эзэмшигч ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх хүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хэрэв компанийн хувьцаа эзэмшигч бол түүний эзэмшлийн хувьцааны төрөл, тоог тусгасан мэдэгдлийг бичгээр гаргах бөгөөд нэр дэвшүүлж байгаа үндэслэлээ зааж болно. Мөн уг мэдэгдэлд санал гаргаж буй нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, эзэмшлийн хувьцааны төрөл, тоог тусгана.

- 4.1.4 НДХ нь энэ журмын 4.1.3-т заасны дагуу гаргасан саналыг дор дурдсанаас бусад тохиолдолд хүлээн авч, нэр дэвшигчдийн жагсаалтад бүртгэн ТУЗ-д танилцуулж, ХЭХ-ын хэлэлцэх асуудлын жагсаалтад уг саналыг хүлээн авснаас хойш ажлын 15 өдрийн дотор багтаан оруулах үүрэг хүлээнэ. Үүнд:
- 4.1.4.1 Санал гаргагч нь энэ журмын 4.1.1-д заасан шаардлагыг хангаагүй;
 - 4.1.4.2 Энэ журмын 4.1.3-т заасан мэдээллийг бүрэн тусгаагүй; болон
 - 4.1.4.3 Энэ журмын 3.3-т заасан ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчид тавигдах шалгуурыг хангаагүй.
- 4.1.5 НДХ нь энэ журмын 4.1.3-т заасны дагуу гаргасан саналыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулах саналыг ТУЗ-д гаргах, эсхүл нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсан бол энэ тухай үндэслэл бүхий тайлбарыг шийдвэр гаргаснаас хойш ажлын 3 өдрийн дотор санал гаргасан хувьцаа эзэмшигчид хүргүүлнэ.
- 4.1.6 Энэ журмын 4.1.5-д заасан НДХ-ны шийдвэрийн талаар санал гаргагч шүүхэд гомдол гаргаж болно.

4.2 Сонгон шалгаруулалт зохион байгуулах шийдвэр гаргах

- 4.2.1 НДХ нь ТУЗ-ийн гишүүдийн идэвх оролцоо, ажлын тайлан, гүйцэтгэлтэй танилцан, компанийн урт хугацааны стратеги төлөвлөлт, бизнесийн чиг хандлагатай уялдуулан ТУЗ-ийн гишүүдийг улираан нэр дэвшүүлэх, эсхүл бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах эсэх шийдвэрийг хэлэлцэн гаргана.
- 4.2.2 НДХ-ны зүгээс ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж шийдвэрлэсэн тохиолдолд ердийн болон хараат бус гишүүдийн тоо, шинээр нэр дэвшүүлэх хараат бус гишүүдийн хэрэгцээ, мэргэжил, ур чадварын нэмэлт шалгуурыг тодорхойлно.
- 4.2.3 ТУЗ-ийн хараат бус гишүүний сонгон шалгаруулалт зохион байгуулах арга хэлбэрийг энэ журмын 3.2-д заасан арга хэлбэрээс сонгон НДХ шийдвэрлэнэ.
- 4.2.4 Шинээр нэр дэвшүүлэх хараат бус гишүүний сонгон шалгаруулалтыг нээлттэй байдлаар зарлан явуулахыг зорих бөгөөд шаардлагатай тохиолдолд өмнө нь сонгон шалгаруулалтад оролцсон нэр дэвшигчид дундаас шууд сонгох байдлаар зохион байгуулж болно.

	ТУЗ-ИЙН ГИШҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ, НЭР ДЭВШҮҮЛЭХ ЖУРАМ	Дугаар: Ж-ТУЗ-134-01
---	--	--------------------------------

4.2.5 Сонгон шалгаруулалт зарлах, хурлаар хэлэлцэх бэлтгэл ажлыг ТУЗАА хариуцан зохион байгуулна.

4.3 Нэр дэвшигчдийг үнэлэх, сонгон шалгаруулах үйл ажиллагаа явуулах

- 4.3.1 НДХ-ны гишүүд нь энэ журмын 3.2-д заасан арга хэлбэрээр ирсэн нэр дэвшигчдийн бичиг баримт, материалууд дээр үндэслэн нэр дэвшигчдийг тус журмын Хавсралт №2-оор баталсан үнэлгээний асуулгын дагуу үнэлнэ.
- 4.3.2 Шаардлагатай тохиолдолд нэр дэвшигчидтэй цахим эсвэл биечилсэн ярилцлага нэмэлтээр хийж болно.
- 4.3.3 ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийг үнэлэх, сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэхдээ тус журмын 3.1-д заасан зарчмыг баримтална.
- 4.3.4 НДХ-ны гишүүд нь нэр дэвшигчдэд үнэлгээ хийн, хэлэлцэн, дүгнэлт гаргасны үндсэн дээр ХЭХ-аар нэр дэвшүүлэх нэр дэвшигчдийг эцсийн байдлаар тодорхойлж нэр дэвшигчдийн жагсаалтыг батлан гаргана.

5. ТУЗ-ИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШҮҮЛЭХ, ТОМИЛОХ

5.1 ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх

- 5.1.1 Энэ журмын 4.1-д заасны дагуу нөлөө бүхий хувьцаа эзэмшигчээс ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэхээр санал ирүүлсэн тохиолдолд НДХ холбогдох шаардлагыг хангаж байгаа эсэхийг хэлэлцэн ТУЗ-д танилцуулж, нэр дэвшигчдийн жагсаалтад оруулан ХЭХ-ын хэлэлцэх асуудалд оруулна.
- 5.1.2 Энэ журмын 4.2-д заасны дагуу НДХ сонгон шалгаруулалт зохион байгуулах шийдвэр гаргасан тохиолдолд тус журмын 4.3-д заасны дагуу ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг үнэлэн, жагсаалтыг гаргаж ХЭХ-ын хэлэлцэх асуудалд оруулна.

5.2 ТУЗ-ийн гишүүнийг томилох

- 5.2.1 ТУЗ-ийн гишүүнийг ХЭХ-аар санал хураах кумулятив аргаар сонгон томилно.
- 5.2.2 Удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан, эсхүл нас барсан ТУЗ-ийн гишүүнийг орлох этгээдийг ХЭХ-аар сонгох хүртэл ТУЗ-өөс түр томилж болно.
- 5.2.3 Энэ журмын 5.2.2-д заасны дагуу томилогдсон гишүүн нь тус журмын 3.3.2-т заасан хараат бус гишүүнд тавигдах шаардлагыг хангасан байх ба ТУЗ-ийн гишүүний эрхийг эдэлнэ.

6. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

6.1 Хяналт тавих

6.1.1 Хувьцаа эзэмшигч нар нь ТУЗ-ийн гишүүдийн сонгон шалгаруулалт, нэр дэвшүүлэх үйл ажиллагаа хууль дүрэм журмын дагуу явагдсан эсэхэд хяналт тавих эрхтэй бөгөөд хувьцаа эзэмшигчийн зүгээс хүсэлт гаргасан тохиолдолд НДХ нь ТУЗАА-аар дамжуулан сонгон шалгаруулалтын явц, үр дүнг ил тодор мэдээлэх үүрэгтэй.

6.2 Хариуцлага хүлээлгэх


6.2.1 НДХ, ТУЗ болон ТУЗАА нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах болон нэр дэвшүүлэх үйл ажиллагаандaa холбогдох хууль тогтоомж болон энэхүү журамд заасан үүргийг мөрдөж ажиллаагүй, зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

ТӨГСӨВ.


7. ХАВСРАЛТУУД

Хавсралт №1 ТУЗ-ийн гишүүн сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх процессын зураглал

Процесс 1. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчээс ирсэн саналын дагуу ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх процесс



Процесс 2. Сонгон шалгаруулалт зохион байгуулах шийдвэрийн дагуу ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшилүүлэх процесс



	ТУЗ-ИЙН ГИШҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ, НЭР ДЭВШҮҮЛЭХ ЖУРАМ	Дугаар: Ж-ТУЗ-134-01
---	--	-------------------------

Хавсралт №2 ТУЗ-ИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

*Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах,
нэр дэвшүүлэх журмын Хавсралт №2-ын маягт 1*

ГОВЬ ХК-ИЙН ТУЗ-ИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙН ТАЛААРХ ДҮГНЭЛТ

№	Нэр дэвшигчийн овог, нэр	ТУЗ-ИЙН ГИШҮҮНИЙ АНГИЛАЛ <i>(Ердийн/Хараат бус)</i>	КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ХАНГАЖ БАЙГАА ЭСЭХ <i>(Тийм/Үгүй)</i>	НЭМЭЛТ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ОНОО <i>(Зөвхөн хараат бус гишүүнд хамаарна)</i>
1				
2				
3				

Дүгнэлт: Дээрх үнэлгээг үндэслэн дараах нэр дэвшигчдийг Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүнд
нэр дэвшүүлэх боломжтой гэж дүгнэж байна.

ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧ

1.
2.
3.

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧ

1.
2.
3.

НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ДАРГА

.....

Огноо: он сар өдөр

Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах,
нэр дэвшүүлэх журмын Хавсралт №2-ын маягт 2

ГОВЬ ХК-ИЙН ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИЙН ҮНЭЛГЭЭ

НЭГ. Нэр дэвшигчийн овог нэр: _____

1. Компанийн тухай хуульд заасан шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэх

№	Шалгуур	Үнэлгээ (Тийм/Үгүй)
1	Иргэний эрх зүйн бүрэн чадамжтай буюу иргэн өөрийн үйлдлээр өөртөө эрх олж, үүрэг бий болгох чадвартай, 18 ба түүнээс дээш настай байх	
2	Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, цэрэг, цагдаа, шүүх, прокурорын байгууллагад удирдах албан тушаал, төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй байх	
3	Тухайн цаг хугацаанд ял шийтгэл эдлээгүй, эрүүгийн гэмт хэрэгт сэжиглэгдээгүй байх	
4	Компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байх	

Үнэлгээг хийсэн:

НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ДАРГА/ГИШҮҮН

.....

Огноо: он cap өдөр

	ТУЗ-ИЙН ГИШҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ, НЭР ДЭВШҮҮЛЭХ ЖУРАМ	Дугаар: Ж-ТУЗ-134-01
---	--	--------------------------------

*Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах,
нэр дэвшүүлэх журмын Хавсралт №2-ын маягт 3*

ГОВЬ ХК-ИЙН ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИЙН ҮНЭЛГЭЭ

НЭГ. Нэр дэвшигчийн овог нэр: _____

1. Компанийн тухай хуульд заасан шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэх

№	Шалгуур	Үнэлгээ (Тийм/Үгүй)
1	Иргэний эрх зүйн бүрэн чадамжтай буюу иргэн өөрийн үйлдлээр өөртөө эрх олж, үүрэг бий болгох чадвартай, 18 ба түүнээс дээш настай байх	
2	Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, цэрэг, цагдаа, шүүх, прокурорын байгууллагад удирдах албан тушаал, төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй байх	
3	Тухайн цаг хугацаанд ял шийтгэл эдлээгүй, эрүүгийн гэмт хэрэгт сэжиглэгдээгүй байх	
4	Компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байх	
5	Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшидэггүй байх	
6	Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаал эрхэлдэггүй, эсхүл сүүлийн 3 жилийн хугацаанд ажил, албан тушаал эрхэлж байгаагүй байх	
7	Компанитай бизнесийн аливаа холбоогүй байх	

2. Нэмэлт шалгуур

№	Шалгуур үзүүлэлт	Тайлбар	Үнэлгээ (1-5 оноо)
1	Компанийн эрх бүхий албан тушаалтантай нэгдмэл сонирхолтой биш, тэдгээрийн төрөл садан, гэр бүлийн гишүүн биш байх		

	ТУЗ-ИЙН ГИШҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ, НЭР ДЭВШҮҮЛЭХ ЖУРАМ	Дугаар: Ж-ТУЗ-134-01
---	--	--------------------------------

2	Компанитай ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг, өрсөлдөгч байгууллагад ажил үүрэг хашдаггүй байх		
3	Ажиллаж буй мэргэжлийн чиглэлээрээ 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай байх		
4	Бизнесийн удирдлагын туршлагатай байх		
5	Санхүү, эдийн засгийн суурь мэдлэгтэй байх		
6	Ноос ноолуур, хөнгөн үйлдвэрлэлийн салбарын суурь мэдлэгтэй байх		
7	Хангалттай цаг зарцуулж ажиллах боломжтой байх		
8	Ёс суртахууны өндөр төлөвшилтэй байх		
9	Идэвх санаачилгатай, хариуцлагатай байх		
10	Аливаа асуудалд дүн шинжилгээ хийж, асуудлыг оновчтой шийдвэрлэх чадвартай		
10	Нэр дэвшиүүлэх хорооноос шинээр бүрдүүлэх ТУЗ-ийн гишүүний хэрэгцээ шаардлагатай уялдуулан тодорхойлсон бусад нэмэлт шалгуур /Жишээ нь: Нарийн мэргэжлийн мэдлэг/		
	Нийт оноо		

Үнэлгээг хийсэн:

НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ДАРГА/ГИШҮҮН

.....

Огноо: он сар өдөр

GOBI MONGOLIAN CASHMERE	ТУЗ-ИЙН ГИШҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ, НЭР ДЭВШҮҮЛЭХ ЖУРАМ	Дугаар: Ж-ТУЗ-134-01
-----------------------------------	--	-------------------------

Хавсралт №3 ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийн анкетын загвар

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД
НЭР ДЭВШИГЧИЙН АНКЕТ**

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Ургийн овог:
Эцэг/ эхийн нэр:
Өөрийн нэр:
Төрсөн он, сар, өдөр:
Төрсөн аймаг, хот:
Регистрийн дугаар:
Оршин суугаа хаяг:
Утасны дугаар:
И-мэйл хаяг:
Эзэмшиж буй Говь ХК-ийн хувьцааны тоо:

Зураг /3x4/

II. ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ /Хамт амьдарч байгаа болон өрхийн бүртгэлд бүртгэлтэй хүмүүсийг бичнэ./

Таны юу болох	Овог, нэр	Регистрийн дугаар	Төрсөн он, сар, өдөр	Одоо эрхэлж буй ажил	Утас

III. БОЛОВСРОЛ /Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ/

Тэгссэн сургууль	Хаана	Элссэн огноо	Тэгссэн огноо	Эзэмшсэн мэргэжил	Зэрэг, цол

IV. АЖИЛ ЭРХЛЭЛТ /Одоо хийж буй ажлаас эхлэн бичнэ/

Албан байгууллагын нэр (Үйл ажиллагааны чиглэл)	Газар, хэлтэс, алба	Албан тушаал	Ажилласан хугацаа (он, сар)	
			Орсон	Гарсан

V. МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ, МЭРГЭШИХ СУРГАЛТ

Зохион байгуулсан улс, байгууллагын нэр	Сургалтын нэр, агуулга	Хамрагдсан хугацаа	Гэрчилгээ, батламж

VI. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН СУРГАЛТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ

Зохион байгуулсан байгууллагын нэр	Сургалтын нэр, агуулга	Хамрагдсан хугацаа	Гэрчилгээ, батламж

	ТУЗ-ИЙН ГИШҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ, НЭР ДЭВШҮҮЛЭХ ЖУРАМ	Дугаар: Ж-ТУЗ-134-01
---	--	---------------------------------------

VII. ГАВЬЯА ШАГНАЛ

Шагналын нэр	Шагнагдсан он	Шагнал олгосон байгууллага

VIII. ЯЛ ШИЙТГЭЛ ЭДЭЛЖ БАЙГАА, ЭРҮҮГИЙН ГЭМТ ХЭРЭГТ СЭЖИГЛЭГДЭЖ БАЙГАА ЭСЭХ

Үгүй Тийм

Хэрэв тийм бол хэзээ, ямар учраас гэдгээ тайлбарлана уу.

.....

.....

IX. УР ЧАДВАР

A. Хэлний чадвар /***-сайн, **-дунд, *-муу/

Гадаад хэл	Ярих			Унших			Бичих			Сонсох		
	***	**	*	***	**	*	***	**	*	***	**	*

B. Хэрэглээний программууд дээр ажиллах чадвар /***-сайн, **-дунд, *-муу/

Хэрэглээний программууд	Чадвар		
	***	**	*
Microsoft оффисын программууд			
Интернет орчин			
Бусад:			

X. ХУВЬ ХҮНИЙ ОНЦЛОГ

Таны давуу тал	Таны сүл тал
Таны ойрын 5 жилийн зорилго	Таны хобби

XI. ХАМААРАЛ БҮХИЙ ЭТГЭЭД /өрх тусгаарласан эцэг, эх, хүүхэд, төрсөн ах, эгч, дүү, эхнэр /нөхөр/, хамтран амьдрагчийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүүг бичнэ./

Ямар хамааралтай болох	Овог, нэр	Регистрийн дугаар	Ажиллаж байгаа байгууллага, сурч байгаа сургууль, Эрхэлж буй ажил, албан тушаал	Бизнес, үйл ажиллагааны чиглэл	Эзэмшиж буй Говь ХК-ийн хувьцааны тоо

XII. НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭД /ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийн талаар бичнэ./

Ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбогдсон хувь хүний нэр	Ямар харилцаатай болох/байсан	Регистрийн дугаар	Ажиллаж байгаа/байсан байгууллага, албан тушаал	Тайлбар (Үйл ажиллагааны чиглэл, зорилго)	Эзэмшиж буй Говь ХК-ийн хувьцааны тоо

	ТУЗ-ИЙН ГИШҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ, НЭР ДЭВШҮҮЛЭХ ЖУРАМ	Дугаар: Ж-ТУЗ-134-01
---	--	--------------------------------

Ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбогдсон хуулийн этгээдийн нэр	Ямар хамааралтай болох	Регистрийн дугаар	Эрхэлж байгаа /байсан үйл ажиллагааны төрөл	Тайлбар (Үйл ажиллагааны чиглэл, зорилго)	Эзэмшиж буй Говь ХК-ийн хувьцааны тоо

XIII. ГИШҮҮНЧЛЭЛ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН

№	Хаана, ямар байгууллагад харьяалалтай болох	Албан тушаал, үүсгэн байгуулагч, гишүүн, дэмжигчийн аль нь болох	Үйл ажиллагааны чиглэл, зорилго	Тайлбар

Тайлбар: Холбоо, нэгдэл, хөдөлгөөн, нутгийн зөвлөлийн тэргүүн, гишүүн, нам, улс төр, олон нийтийн байгууллагын гишүүнчлэлд байсан болон байгаа талаар бичнэ.

XIV. ОДООГИЙН ХАШИЖ БАЙГАА АЖИЛ, АЛБАН ТУШААЛ ТӨРИЙН АЛБАНД ХАМААРДАГ ЭСЭХ

Үгүй Тийм

Хэрэв тийм бол албан байгууллага болон албан тушаалын нэр:

.....
Төрийн албан тушаалын төрөл:

Төрийн улс төрийн албан тушаал	
Төрийн захиргааны албан тушаал	
Төрийн тусгай албан тушаал	
Төрийн үйлчилгээний албан тушаал	

Гарын үсэг /баталгаат/:

Огноо: он сар өдөр